



**БУЛГАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/ЫО

Булган сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 15 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Бүрэгхангай сумын төвийн шинэ суурьшлын бүсийн амины орон сууцны хэсгийн ариутгах татуургын гадна инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг Бүрэгхангай сумын Засаг даргын Тамгын газар, “Тэргүүн майнинг” ХХК, “Булган Мээж” ХХК-тай байгуулсан барилга угсралтын ажлын гэрээний үлдэгдэл санхүүжилтийг аймгийн оролцооны хөрөнгө болох 50,346,989 (Тавин сая гурван зуун дөчин зургаан мянга есөн зуун наян ес) төгрөгийг Бүрэгхангай сумын Засаг даргын Тамгын газарт олгосугай.

2.Аймгийн оролцооны хөрөнгийг холбогдох хууль журмын хүрээнд гэрээ дүгнэж, санхүүжилтийг олгохыг Бүрэгхангай сумын Засаг дарга (М.Бадам)-д даалгасугай.

3.Дээрх инженерийн шугам сүлжээний ажилд чанар болон ашиглалтад хяналт тавьж хүлээн ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн), Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга), Бүрэгхангай сумын Засаг дарга (М.Бадам)-д тус тус даалгасугай.

4.Дээрх оролцооны хөрөнгийн санхүүжилтийг аймгийн байгаль хамгаалах сангийн батлагдсан төсвөөс гэрээнд заагдсан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Сугар Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010846